



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 14 өдөр

Дугаар А/81

Улаанбаатар хот

Мэргэжлийн үйл ажиллагаа
эрхлэх зөвшөөрөл олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8, Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 98 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гадаадын эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, хүчингүй болгох журам"-ын 2.7, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Гамшгийн болон хүмүүнлэг туслалцааны олон улсын байгууллага Самаританс Пурс хооронд байгуулсан "Монгол Улс дахь хүүхдийн зүрх төсөл" харилцан ойлголцлын санамж бичгийн 1, 2 дахь заалт, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн 2016 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсад мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох гадаадын 1 эмнэлгийн мэргэжилтний нэр, төрөлжсөн мэргэшлийн чиглэл, зөвшөөрлийн төрөл, хүчинтэй хугацааг хавсралтаар баталсугай.

2. Зөвшөөрлийн гэрчилгээг бичиж олгохыг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал /Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга /Д.Очирбат/-д даалгасугай.



САЙД

А.ЦОГЦЭЦЭГ

080388



МОНГОЛ УЛСАД МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ
 ГАДААДЫН ЭМНЭЛГИЙН МЭРГЭЖИЛТНИЙ НЭР, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭШЛИЙН ЧИГЛЭЛ,
 ЗӨВШӨӨРЛИЙН ТӨРӨЛ, ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

№	Овог нэр	Харьяалал	Ажиллах байгууллага	Гэрчилгээний сери/дугаар	Төрөлжсөн мэргэжлийн чиглэл	Зөвшөөрлийн төрөл	Зөвшөөрлийн хүчинтэй хугацаа
1.	Фергусон Мэтью Эрик Ferguson Matthew Eric	АНУ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв	ГЭ0001657	Хүүхдийн зурх судас	Эмчлэх	2016.10.17- 2016.10.20 /4 хоног/